



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№67 /511/

2023.04.25

Цаг үе, үйл явдал

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮД БХЯ, ЗХЖШ-Т АЖИЛЛАЛАА



Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний Жанжин штабт ажиллалаа.

Эхлээд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн мөрийн хөтөлбөр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар товч танилцууллаа.

Үүний дараа Байнгын хорооны гишүүд батлан хамгаалахын салбарт хэрэгжүүлж буй ажлууд болон цаашид ажиллах төлөвлөгөө, тулгамдаад буй асуудлуудын талаар яамны удирдлагуудтай санал солилцов.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр тус салбарт ажиллаж буй албан хаагчдын цалин урамшуулал, тэтгэвэр тэтгэмжийн асуудлыг оновчтой шийдэх шаардлагатай байгааг дурдаад цаашид холбогдох хууль, тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэл хийх тал дээр Байнгын хорооны гишүүдийг дэмжин ажиллахыг хүслээ.

Түүнчлэн салбарын хүрээнд төсвийн дутагдалтай байдал нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл үзүүлж болзошгүй байгааг хэллээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нь Нийгмийн даатгалын багц хуулийн хамт боловсруулагдаж байгааг энэ үеэр онцоллоо.

Мөн Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь өнөө үед чухал асуудал болсон. Энэ тал дээр Байнгын хороо онцгой анхаарч ажиллана.

Түүнчлэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд яаралтай өөрчлөлт оруулах нь зүйтэй. Энхийг дэмжих ажиллагаа нь Батлан хамгаалах яамны санхүүжих том эх үүсвэрүүдийн нэг. Байнгын хороотой хамтран ажиллаж эдгээр хуулиудыг яаралтай өргөн барих хэрэгтэй байна гэлээ.

Үргэлжлүүлэн Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд ЗХЖШ-т ажиллаж шинээр байгуулагдсан төрлийн цэргийн 3 командлалын үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонсож холбогдох санал, зөвлөмжийг өгч ажилласан юм.

ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД БХЯ МАНЛАЙЛАН ОРОЛЦОНО



дэд сайдаар ахлуулсан бүлэг ажиллаж эрүүл зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, сэтгэхүйн эрүүл мэндээ хэрхэн хамгаалах талаар ажилтан, цэргийн алба хаагчдад мэдээлэл өглөө.

Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай уг арга хэмжээг нээж хэлсэн



үгэндээ эрүүл чийрэг бие бялдартай, зөв ёс зүйтэй, ажил албандаа эзэн болсон, мэдлэг боловсрол, дадлага туршлагатай иргэн, цэргийн алба хаагчийг төлөвшүүлэх юу юунаас илүү чухал асуудал болохыг

онцлоод нийт бие бүрэлдэхүүнд архины зохисгүй хэрэглээнээс ажил гэр, хамт олны хүрээнд бүр мөсөн татгалзаж, урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, тогтмол биеийн тамирын дасгал хөдөлгөөн хийж байхыг уриаллаа.

Үргэлжлүүлэн ШУТИС-ын багш, дэд профессор М.Пүрэвжав, АШУУИС-ын багш Р.Энхтүвшин, Гимнастикийн олон улсын хэмжээний мастер, дэд профессор Ж.Тунгалаг, Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын ахлах байцаагч цагдаагийн ахмад Т.Жавхлан нар "Эрүүл зөв хооллолт", "Сэтгэл бол эрхтэн", "Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл мэнд", "Согтууруулах ундаанаас үүдэлтэй хор уршиг, түүнийг бууруулах шинэ хандлага" сэдвээр тус тус илтгэл танилцуулж, нийт бие бүрэлдэхүүний сонирхсон асуултад нь хариуллаа.

Монгол Ерөнхийлөгч, хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн хэрэгжиж буй "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөнд БХЯ, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцож байна. Тухайлбал, Уг хөдөлгөөний хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангиудад Батлан хамгаалахын

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	-1

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	26

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,483	3,487
EUR	3,860	3,880
CNY	506	507.50
RUB	42,20	42.70
JPY	25.95	26.10
KRW	2.63	2.66

ЗУРХАЙ

2023.04.25 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 5

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:
Эд мал сайжирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.45-19.55
Барилдлага:
Үхэх
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Хурьцахуй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 686,587,938

Эдгэрсэн

Нийт: 659,153,325

Нас барсан

Нийт: 6,860,231

Цахим шууданд

НЭГДСЭН АЖИЛЛАГААНЫ ТӨВИЙН БАРИЛГЫН ШАВ ТАВИВ



Энэ сарын 24-ний өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын Нэгдсэн ажиллагааны төвийн барилгын шав тавих ёслолын ажиллагааг зохион байгуулав. Энэхүү ёслолд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба болон ЗХЖШ-ын орлогч дарга нар, Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, Төрлийн цэргийн командлагч, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын удирдлага, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч, уг барилгын ажлыг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн оролцлоо.

Ёслолын ажиллагааны эхэнд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба хэлсэн үгэндээ “Аливаа байгууллагын ажлын амжилт, хөдөлмөрийн бүтээмж, үр дүн нь хүний хүчин зүйлээс ихээхэн шалтгаалахын зэрэгцээ ажлын байрны орчин нөхцлөөс шууд хамаардаг. Монгол Улсын төр, засаг, Батлан хамгаалах яамнаас Зэвсэгт

хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавх, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тэдний ажиллаж, амьдрах орчин нөхцөл болоод нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр олон талт ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлсээр ирсэн юм. Энэ удаа сүүлийн үед цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагын дэвшүүлсэн хамгийн чухал асуудлыг шийдвэрлэн өгч байгаа Батлан хамгаалахын сайд Танд талархсанаа илэрхийлье.

Зэвсэгт хүчний бүтцэд Барилга-инженерийн цэргийн удирдах газрыг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлсний үр дүн өдгөө гарч, энэхүү барилгыг барьж ашиглалтад оруулах өндөр хариуцлагатай ажлыг Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн барилгачин дайчид гүйцэтгэх болно. Иймд Та бүхэн уг барилгын ажлыг мэргэжил, ур чадвараа бүрэн дайчилж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд сахин, тогтоосон

хугацаанд нь чанарын өндөр түвшинд гүйцэтгэнэ гэдэгт итгэл төгс байна” гэдгийг онцоллоо.

Мөн энэ үеэр Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч хурандаа Б.Дорждэрэм “Тус анги олон арван бахдам түүхтэй бөгөөд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотын хөгжил дэвшилд жинтэй хувь нэмэр оруулж, эх орныхоо өнцөг булан бүрт, хэрэгцээтэй газарт нь төр, засаг, цэргийн удирдлагаас өгсөн үүргийг нэр төртэйгөөр гүйцэтгэж ирсэн юм. Өнгөрсөн хугацаанд бид бүхэн Зэвсэгт хүчний 350 дугаар анги, Хуурай замын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын барилгыг барьж, ашиглалтад оруулсан бөгөөд энэ удаа тус барилгыг барих үүргийг бидэнд даалгасанд баяртай байна. Тус ангийн хамт олон энэхүү өндөр хариуцлагатай үүргийг цаг хугацаанд нь гүйцэтгэж, чанартай хүлээлгэн өгөх болно” хэмээсэн юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫН БОГИНО ХУГАЦААНЫ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Сургалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн сургагч багшийн дамжаанд хамрагдсан дэд хурандаа Ө.Баярбадрах, ахмад М.Болд-Эрдэнэ нар удирдан явуулж байгаа юм.

Сургалтыг Улаанбаатар цэргийн хүрээний Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд хөтөлбөрийн дагуу нэгэн зэрэг сургалтаа эхлүүлсэн ба Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академи, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газраас хичээлийн явцад цахимаар хяналт тавин ажиллаж байна.

Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчидтай Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын богино хугацааны сургалтыг ЗХЖШ-ын даргын тушаалаар 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 28-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Энэхүү сургалтын зорилго нь урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн гол агуулга, хүрэхээр зорьж буй үр дүн, төрийн бодлого, шийдвэрийн уялдааг хугацаат цэргийн алба хааж байгаа залуучуудад таниулж, бодлогыг хэрэгжүүлэхэд залуучуудын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.



САГСАН БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД ЭМЭГТЭЙЧҮҮД МӨНГӨН МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Хил хамгаалах албаны 90 жилийн ойг тохиолдуулан ХХЕГ-аас Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулсан сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн амжилттай явагдаж, дүнгээ гаргалаа.

Тэмцээнд эрэгтэй 10, эмэгтэй 9 багийн 180 орчим алба хаагч оролцож хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эрэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт ТЕГ, дэд байрт ШШГЕГ, гутгаар байрт ОБЕГ-ын баг тамирчид, эмэгтэйчүүдийн төрөлд тэргүүн байрт ХХЕГ, дэд байрт ЗХЖШ, гутгаар байрт ШШГЕГ-ын баг тамирчид тус тус шалгарч мөрдөс нэгт нөхдөө манлайллаа.

Дэд хурандаа С.ЭНХТАЙВАН

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН “ДӨЛ-2023” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТ БОЛЛОО



Баянгол дүүргийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний нээлт өнөөдөр буюу 4 дүгээр сарын 25-ны өдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангид зохион болж өндөрлөлөө.

Тус тэмцээн нь ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдад цэрэг, эх оронч үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэвчээр хатуужил олгох, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний залгамж халааг бэлтгэх, цэргийн хөдөлмөрийн онцлогийг сурталчлан таниулах ач холбогдолтой юм.

Энэ удаагийн тэмцээнд

дүүргийн 14 сургуулийн 200 гаруй сурагчид оролцож, гарааны өмнөх ажиллагаа буюу жагсаал, гардан тулааны үзүүлэх тоглолт, тасгийн захирагчийн тэмцээн, галын бэлтгэлийн норматив, марш гүйлтийн тэмцээн зэрэг цэрэг-спортын 10 төрлөөр хурд, хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдөж байна.

Мөн энэ жилийн цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээн нь Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102, Монгол цэрэг Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны 21 жилийн ойн хүрээнд зохиогдож байгаагаараа онцлогтой байна.



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 017 ДУГААР АНГИ “АЛСЫН ХАРАА 2050” ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТАНИЛЦУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын гол агуулга, хүрэхээр зорьж буй үр дүн, төр, засгаас гарч буй бодлого, шийдвэрийн уялдаа холбоо, агуулгыг хугацаат цэргийн алба хааж байгаа залуучуудад таниулж, ирээдүйд энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд залуу хүний оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий сургалтыг эхлүүллээ.

Энэхүү сургалтыг тус ангийн хугацаат цэргийн алба хаагчидтай энэ сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Хошууч М.ДАВААНЯМ

